



МҮХАҮТ-ЫН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Гишүүд, нийт бизнес эрхлэгчдийн эрх ашгийг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлэх ажлыг шинэ шатанд гаргах, бизнесийн хууль эрх зүйн орчинг эрс сайжруулах, эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтыг дэмжсэн бодлогын шинэчлэл хийх, нийгэм дэхь хувийн хэвшлийн байр суурь, нэр хүндийг дээшлүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг эрчимжүүлэх үндсэн зорилтын хүрээнд МҮХАҮТ-аас 2015 оныг

“САНХҮҮГИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛ”

болгон зарлаж байна.

ХАҮТ-ын тухай монгол улсын хууль, МҮХАҮТ-ын дүрэм, дээрх зорилтын хүрээнд МҮХАҮТ-аас дараах асуудлуудад үйл ажиллагаагаа чиглүүлэн нийт газар хэлтэс, ажилтнуудын идэвхи санаачлагыг өрнүүлэн ажиллах болно.

1. Хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр

- Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг яаралтай батлан гаргуулахад хувийн хэвшлийнхнийг манлайлах замаар бизнесийн орчинг эрүүлжүүлэх, бизнесийн таатай нөхцөл бүрдүүлэх
- Татварын хуулиудын шинэчлэлийг түргэвчлүүлэх, нэн ялангуяа НӨАТ-ын хуулийг нийт бизнесийнхний ашиг сонирхолд нийцсэн, бизнест дарамт чирэгдэл учруулахгүй байх зарчимд үндэслэн гаргуулах
- Нийгмийн даатгалын, тэтгэвэрийн болон хөдөлмөрийн хуулийг зах зээлийн зарчим, ажил олгогч, ажилтны аль алиных нь эрх ашигт нийцүүлсэн, хөдөлмөрийн тэгш, шударга харилцааг бий болгосон байдлаар шинэчлэн гаргуулах
- Худалдааны тухай хуулийг шинэчлэн боловсруулж төр худалдааны бодлогоо тодорхойлж түүнийг хэрэгжүүлэгч, зохион байгуулагч, чиглүүлэгч нь Танхим байх чиглэлээр хуулийг гаргуулах, лоббидох
- Өмчийн тухай хуулийг яаралтай батлан гаргуулахад танхим идэвхитэй оролцох, төрийн болон олон нийтийн өмчийн эрх зүйн зөв орчинг бүрдүүлэх замаар эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах

- 1995 онд батлагдсан ХАҮТ-ын тухай монгол улсын хуулийг өнөөгийн цаг үе, зах зээл, эдийн засаг, бизнесийн цаашдын хөгжил, өөрчлөлттэй уялдуулан шинэчлэх, Танхимын төрийн бодлого шийдвэрт нөлөөлөх, оролцох оролцоог хуульчлан бататгах талаар санаачлагатай ажиллах
- Бизнес, эдийн засагтай холбоотой гарч буй аливаа хууль, тогтоол, бодлого шийдвэрүүдэд хувийн хэвшлийнхний санал бодол, туршлага мэдлэгийг заавал авдаг, тусгадаг байх эрх зүйн нөхцөл, боломжийг бүрдүүлэх
- Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, хэрэглээг нь нэмэгдүүлэх үүднээс импортын татварыг нэмэгдүүлэх талаар санал боловсруулан УИХ, Засгийн газарт хүргүүлэх
- Хуулийн тогтвортой байдлыг хангах үүднээс ойрын 5-10 жилд өөрчлөлт оруулахгүй байх шарадлагатай тодорхой хуулиудын жагсаалт гаргаж УИХ, холбогдох байгууллагуудад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих

2. Хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, уялдаа холбоо, хүчин чармайлтыг нэмэгдүүлэх чиглэлээр

- 2015-2018 онуудад Танхимаас эдийн засаг, бизнесийн болоод хууль эрх зүйн орчинг сайжруулах, хувийн хэвшлийг дэмжих, төр засагтай харилцах, гишүүдээ дэмжин туслах чиглэлүүдээр баримтлан ажиллах стратеги боловсруулан хэрэгжүүлэх
- Хувийн хэвшлийн голлох байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулан хувийн хэвшлийн нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг ролийг нэмэгдүүлэх чиглэлд идэвхитэй ажиллах
- “Хувийн хэвшлийг дэмжих үндэсний стратеги”, “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого” зэрэг баримт бичгүүдийг бодит ажил, үр дүн болгох чиглэлд холбогдох бүхий л байгууллагуудтай идэвхитэй ажиллах
- Хувийн хэвшлийнхний санал санаачлагаар хөрөнгө оруулалтаар бизнесийг дэмжсэн төрөл бүрийн сан байгуулах ажлыг Танхим бүрэн дэмжиж хамтран ажиллах, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг ч энэ чиглэлд татах, идэвхижүүлэх чиглэлд анхаарлаа хандуулах
- Бизнесийн шударга өрсөлдөөнийг эрчимжүүлэх, хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлд төр засаг, олон улсын байгууллагууд, бусад ТББ, хувийн хэвшлийнхний үйл ажиллагааг нэгтгэн уялдуулах ажлыг танхим манлайлан оролцох, чиглүүлэх
- Хувийн хэвшлийнхний тулгамдсан асуудлын нэг болох мэргэжилтэй, чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх, сургах чиглэлд хамтран ажиллах, зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, өндөр технологи, мэдлэг эзэмшсэн мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэн гаргахад төрийн бодлогыг чиглүүлэх

3. Санхүүгийн шинэчлэлийг эрчимжүүлэх чиглэлээр

- Жижиг дунд бизнес, үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжсэн, тэдний үйл ажиллагааг өргөжүүлэн тэлэхэд чиглэсэн, баялаг бүтээгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэхэд төр, засгийн холбогдох байгууллагуудтай идэвхитэй хамтран ажиллах

- Нийт бизнес эрхлэгчид, гишүүн байгууллагуудын санхүүгийн эрх чөлөөг хангах, хямд, хөнгөлттэй нөхцөл бүхий санхүүжилтийн найдвартай эх үүсвэрээр хангуулах эрхийг нь эдлүүлэх, санхүүгийн шинэчлэл хийх замаар эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг багасгах талаар төр засагтай яриа хэлцэл хийх, хэрэгжүүлэх чиглэлд тууштай ажиллах
- Үндэсний манлай аж ахуйн нэгжүүдийг дэмжих хөтөлбөрийг төрийн бодлогод оруулан хэрэгжүүлэх чиглэлд холбогдох байгууллагуудтай ажиллах, бүтээн байгуулалт хийж буй томоохон компаниудыг бодлогоор, цогцоор дэмжих талаар санал боловсруулан Засгийн газарт хүргэх
- Үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжин олон тулгуурт эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх замаар бизнесийн санхүүжилтийг дэмжих арга хэрэгслүүдийг нэвтрүүлэн өргөжүүлэх

4. Бодлогын өмгөөллийн чиглэлээр

- Бизнесийн орчинг сайжруулах, бизнесийг дэмжих, салбаруудыг хөгжүүлэх чиглэлээр МҮХАҮТ-аас баримтлах бодлого, өгөх дүгнэлт, гаргах бичиг баримтуудыг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн боловсруулан гаргах
- Танхимаас санаачилсан “Бизнесийн парламент”-ыг бодит ажил хэрэг болгон эдийн засаг, бизнесийн холбоотой гол гол хуулиудыг батлах, боловсруулах, өөрчлөн шинэчлэхэд хувийн хэвшлийн оролцоог тогтмолжуулах
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрс шинэчилж Засгийн газар, хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хорооны ажлыг байнгын, тогтвортой, үр дүнтэй, хувийн хэвшлийн бусад холбоод, байгууллагуудыг нэгтгэсэн үндэсний хэмжээний механизм болгох чиглэлд санаачлагатай ажиллах
- Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлэх асуудлыг ажил хэрэг болгох үүднээс Танхимаас санаачлан хуулийн төсөл боловсруулан Их хуралд оруулан шийдүүлэх чиглэлд идэвхитэй ажиллах
- Танхимын дэргэдэх салбар зөвлөлүүдийг тухайн салбарын бодлогын өмгөөлөл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн механизм болгох, танхимын Тэргүүлэгч гишүүн бүр нэг нэг зөвлөл хариуцан ажиллаж үр дүнд хүргэх
- Төрийн байгууллагуудын хүнд суртлыг багасгах, авлига хээл хахуулийг багасгах чиглэлд идэвхитэй ажиллан энэ чиглэлд Танхимаас хийх, авч хэрэгжүүлэх ажлыг улирал, жилээр төлөвлөн бодитой үр дүнд хүргэн ажиллах
- Гишүүд, бизнес эрхлэгчдийг нэн шаардлагатай хууль эрх зүйн мэдээллээр тогтмол хангадаг, зөвлөдөг, тусалдаг механизм бий болгон эргэх холбоотой ажиллах

5. Бизнесийг дэмжин урамшуулах чиглэлээр

- Гишүүд, нийт бизнес эрхлэгчдэд чиглэсэн үйлчилгээг өргөжүүлэх, тэдэнд шаардлагатай байгаа мэдээ мэдээлэл, сургалт, судалгааг цаг алдалгүй хүргэж байх, гадаад дотоодын бизнесийнхэнтэй холбоход үзүүлэх дэмжлэг тусалцааг тодорхой, бодитой болгох
- Хоёр хөрштэйгээ хийх эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг өргөжүүлэхэд гурван талын ХАҮТ-ын хамтын ажиллагааг өргөжүүлэх, нэн ялангуяа урд хөрштэй хиллэдэг хилийн боомтуудын ажиллах цагийг уртасгах чиглэлд анхаарах

- Худалдааг хөнгөвчлөх, гадаад худалдааны зохицуулалтыг багасгах, гадаад худалдааны Цахим нэг цонх хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэх, экспортыг хөгжүүлэх үндэсний хэмжээний хөтөлбөрийг олон улсын болоод төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх чиглэлд идэвхитэй ажиллах
- Бөөний худалдааны сүлжээг бий болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах
- Бичил, жижиг бизнесийг дэмжих татварын болоод санхүүгийн орчин бүрдүүлэх замаар нийгмийг бүрдүүлэгч дундаж ангийг нэмэгдүүлж ядуурлыг багасгах чиглэлд Танхим өөрийн байр суурь, оролцоо, хувь нэмрийг улам өргөжүүлэх
- Экспортын нэг цэгийн үйлчилгээ бий болгох замаар хүнд суртал, зардал чирэгдлийг багасгах, экспортын даатгалын тогтолцоог бий болгох чиглэлд олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах